МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Олимпийн гудамж 2, Засгийн газрын VIII байр,
Утас: 26-36-95, Факс: (976-11) 32-35-41, 32-09-16
И-мэйл: moh@moh.gov.mn, http://www.mohs.mn

2018.05.31 № 8/2195

танай ____________-ны № ____________-т

ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЭМНЭЛЭГ,
ТУСГАЙ МЭРГЭЖЛИЙН ТӨВ, АЙМАГ,
ДҮҮРГИЙН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН ДАРГА
ЗАХИРАЛ НАРТ

Монгол улсын Засгийн газрын "2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө"-ний 3.1.9 дэх зорилтын 2-т "Эрүүл мэндийн байгууллагуудын клиник эм зүйн тусламж, үйлчилгээг үе шаттайгаар өргөжүүлэх"-ээр заасан билээ. Энэхүү арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор Эрүүл мэндийн сайдын 2018 оны 5 дугаар сарын А/209 дугаар тушаалаар батлагдсан "Эмнэлэгт эмнэлзүйн эмзүйн тусламж үйлчилгээг өргөжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө"-г хавсралтаар хүргүүлж байна. Холбогдох арга хэмжээг авч ажиллана уу.

ЭМ, ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН
ГАЗРЫН ДАРГА Д.ОЮУНЧИМЭГ

9087443 УХА0578 1116126516

082472

МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2018 оны 05 сарын 28 өдөр | Дугаар А/209 | Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолыг үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө"-ний 3.1.9 дэх зорилтын 2 дахь арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор "Эмнэлэгт эмнэлзүйн эмзүйн тусламж үйлчилгээг өргөжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө"-г хавсралтаар батласугай.

2. Төлөвлөгөөнд заасан үйл ажиллагааг байгууллагынхаа жилийн төлөвлөгөөнд тусган, тайланг жил бүрийн 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Эм, эмнэлгийн хэрэгсэл, үйлдвэрлэлийн хэлтэст ирүүлж байхыг Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв болон аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эм, үйлдвэрлэл, технологийн газар /Д.Оюунчимэг/-т даалгасугай.

САЙД Д.САРАНГЭРЭЛ

080884

Эрүүл мэндийн сайдын 2018 оны
05 дугаар сарын 28 өдрийн ... дугаар
тушаалын хавсралт

## ЭМНЭЛЭГТ ЭМНЭЛЗҮЙН ЭМЗҮЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭГ ӨРГӨЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

| | Үйл ажиллагаа | Он | | | Хэрэгжүүлэгч байгууллага | Шалгуур үзүүлэлт |
|---|---|---|---|---|---|---|
| | | 2018 | 2019 | 2020 | | |
| | **Чиглэл 1. Эмнэлэгт эмнэлзүйн эмзүйн тусламж үйлчилгээг үзүүлж буй эмзүйчийг стандартын дагуу бүрэн орон тоогоор ажиллуулах** | | | | | |
| 1.1 | Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв эмнэлзүйн эмзүйч нарын орон тоо, ажлын байр, ажлын ачааллын талаар судалгаа хийх | + | | | ЭМЯ, ЭМХТ, МХЕГ | МХЕГ-тай хамтран төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн эмнэлзүйн эмзүйчийн стандартын дагуу хангалттай орон тоогоор ажиллаж буй байдалд хийсэн судалгааны дүн |
| 1.2 | Судалгааны дүнд үндэслэн "Эмийн санд тавих нийтлэг шаардлага" MNS 5260:2015 улсын стандартын дагуу батлагдсан орон тоондоо багтаан эмнэлзүйн эмзүйчийг бүрэн орон тоогоор ажиллуулах талаар эрүүл мэндийн байгууллагад зөвлөмж хүргүүлэх | | + | | ЭМЯ, ЭМХТ | Дээрх үнэлгээний дүнд үндэслэн эрүүл мэндийн байгууллагад хүргүүлсэн зөвлөмж |
| 1.3 | Дээд боловсролтой эмзүйч бэлтгэж буй анагаахын боловсрол олгож буй их дээд сургуулиудад эмнэлзүйн эмзүйч бэлтгэх "Pharm D /Doctor of Pharmacy/" хөтөлбөрийг нэвтрүүлэх талаар хамтран ажиллах | | + | + | АШУҮИС-ийн Эм судлалын тэнхим, Эмзүйн сургууль, Эмзүйн шинжлэх ухааны их сургууль | Эмнэлзүйн эмзүйч бэлтгэх "Pharm D" хөтөлбөрийг нэвтрүүлж эхэлсэн Эмзүйн боловсрол олгож буй их дээд сургуулиудын тоо |
| 1.4 | Эмнэлзүйн эмзүйчийг жил бүр мэргэшүүлсэн сургалтаар бэлтгэх | + | + | + | АШУҮИС-ийн Эм судлалын тэнхим, Эмзүйн сургууль, Эмзүйн шинжлэх ухааны их сургууль | Жилд бүр 25-аас доошгүй эмнэлзүйн эмзүйч бэлтгэгдсэн тайлан |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 1.5 | Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн эмзүйч нарт болон эмнэлгийн дарга, эмч, чанарын алба, сургалт, гадаад харилцааны алба, хүний нөөцийн ажилтанд "Эмнэлзүйн эмзүйчийн ажлын байр, гүйцэтгэх үүргийн ач холбогдол" сургалтыг зохион байгуулах | + | | | ЭМЯ, АШУҮИС-ийн Эм судлалын тэнхим, Эмзүйн сургууль, Эмзүйн шинжлэх ухааны их сургууль | Сургалтад 40-өөс доошгүй мэргэжилтэн албан тушаалтан хамрагдсан тайлан |
| 1.6 | Эмнэлзүйн эмзүйчийн мөрдөх стандарт үйл ажиллагааны зааврыг орчуулж, эрүүл мэндийн байгууллагуудад түгээх | | + | | ЭМЯ, ЭМХТ | Орчуулсан зааврыг төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв болон аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгүүдэд хүргүүлсэн байна. |
| 1.7 | Эмнэлзүйн эмзүйч эмчлүүлэгчийн эмийн эмчилгээтэй холбоотой гарсан асуудал шийдвэрлэхийн тулд хөтөлдөг /нэг загвартай/ анхан шатны бүртгэлийн загвар боловсруулж, стандартын хавсралтад оруулах санал боловсруулах | | | + | Эмзүй, эм судлалын мэргэжлийн зөвлөл, АШУҮИС-ийн Эм зүйн сургууль, Эмзүйн шинжлэх ухааны их сургууль, Эрүүл мэндийн байгууллагууд | Эмнэлзүйн эмзүйчийн хөтлөх анхан шатны маягтыг загвар гарсан байна. |
| 1.8 | 1 эмнэлзүйн эм зүйчийн ажлын ачааллыг ор хоногоор тооцох боломжгүй өөрөөр хэлбэл эмнэл зүйн онцгой тусламж нэн шаардлагатай тасгуудад ажиллах эм зүйчийг тусгайлан зааж өгөх талаар стандартад оруулах санал зөвлөмж гаргах | | + | | Эмзүй, эм судлалын мэргэжлийн зөвлөл, АШУҮИС-ийн Эмзүйн сургууль, Эмзүйн шинжлэх ухааны их сургууль, Эрүүл мэндийн байгууллагууд | Эмийн сангийн стандартад оруулах саналыг боловсруулж ЭМЯ-д ирүүлсэн байна. |
| 1.9 | Эрүүл мэндийн байгууллагуудад цахим жор, "эмийн нэгж тугналтын савлалт"-ын системийг нэвтрүүлэх | | + | + | ЭМЯ, Эрүүл мэндийн байгууллагууд | "цахим жор, эмийн нэгж тугналтын савлалт"-ын системийг нэвтрүүлсэн эрүүл мэндийн байгууллагын тоо |
| | **Чиглэл 2. Эмнэлзүйн эмзүйчийн ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргийн дагуу үүрэг гүйцэтгэх** | | | | | |
| 2.1 | Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв эмнэлзүйн эмзүйч нарын ажлын байрны тодорхойлолт болон үр дүнгийн гэрээний | + | | | ЭМЯ, ЭМХТ, МХЕГ | МХЕГ-тай хамтран төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн эмнэлзүйн |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | уялдаанд үнэлгээ хийх | | | | | эмзүйчийн ажлын байрн... тодорхойлолт болон 2017 оны үр дүнгийн гэрээний тайланд үнэлгээ хийсэн байна. |
| 2.2 | Үнэлгээний дүнд үндэслэн Эрүүл мэндийн сайдын 2012 оны 182 дугаар тушаалын 15 дугаар хавсралтаар батлагдсан "Эмнэлзүйн эмзүйчийн ажлын байрны тодорхойлолт"-ын дагуу ажиллуулах талаар зөвлөмж хүргүүлэх | | + | | ЭМЯ, ЭМХТ | Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэгт МХЕГ-тай хамтран эмнэлзүйн эмзүйчийг бүрэн орон тоогоор ажиллуулах албан бичгийг хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавина |
| 2.3 | Эмнэлзүйн эмзүйч нарыг эмнэлгийн эмчилгээний тасгуудад эмчилгээ, оношлогооны стандартад, удирдамжинд үнэлгээ хийхэд оролцох, эмч нартай харилцан мэдээлэл солилцож ажиллах талаар үр дүнгийн гэрээ, ажлын байрны тодорхойлолтод тусгаж, дүгнэх | + | + | + | Эрүүл мэндийн байгууллагууд | Эмнэлзүйн эмзүйчийн ажлын байрны тодорхойлолтод өөрчлөлт оруулж, байгууллагын дарга баталсан байна. |
| 2.4 | Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд эмнэлзүйн эмзүйч нар нь эмийн зохистой хэрэглээ, эмийн эмчилгээнээс гарах алдаанаас урьдчилан сэргийлэх талаар төлөвлөгөө гарган сургалт явуулж хэвших | + | + | + | Эрүүл мэндийн байгууллагууд, АШУҮИС-ын Эм судлалын тэнхим, Эмзүйн шинжлэх ухааны их сургууль | Төлөвлөгөөний дагуу давтамжтай сургалтуудыг явуулна |
| 2.5 | Эмнэлзүйн эмзүйчдийг эмчилгээний тасгуудын онцлогийг харгалзан төрөлжин мэргэших боломжоор хангах, хариуцсан тасгийн үйл ажиллагаанд туршлагажих боломжийг ажлын байрны шаардлагад тусгах /мэдээгүйжүүлэх эрчимт эмчилгээний тасаг, мэс заслын тасаг, хүүхдийн тасаг, зүрх судас судлал тасгийн эмнэл зүйн эм зүйч гэх мэтээр ялгаатай байх/ | + | + | + | Эрүүл мэндийн байгууллагууд | Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвд нарийн мэргэшлийн чиглэлийн эмнэлзүйн эм зүйч ажиллах талаар ажлын байрны тодорхойлолтод оруулж эхэлсэн байна. |
| 2.6 | Эмнэлзүйн эмзүйч бэлтгэх төгсөлтийн дараах мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийг үнэлж, шинэчилж байх | + | + | + | АШУҮИС-ийн Эмзүйн сургууль, Эмзүйн шинжлэх | Эмзүйн боловсрол олгож буй их дээд сургуулиуд сургалтын хөтөлбөрөө шинэчилсэн байна. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ухааны их сургууль | |
| | Эмийн харилцан үйлчлэлийн талаар эрүүл мэндийн байгууллагын удирдлага, эмнэлзүйн эмзүйч нарт танилцуулга мэдээллийг зохион байгуулах | + | + | | АШУҮИС-ийн Эм судлалын тэнхим, Интермед эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагууд | Сургалтыг эмнэлэг бүр дээр болон тусгайлсан хөтөлбөрөөр зохион байгуулсан байна. |
| | Эмнэлзүйн эмзүйч нарт зориулсан эмийн эмчилгээний алгоритм, өвчний тохиолдолд үзүүлэх эм зүйн тусламж үйлчилгээний чиглэлээр гарын авлага боловсруулах, орчуулах | + | + | + | АШУҮИС-ийн Эмзүйн сургууль, Эм судлалын тэнхим, Эмзүйн шинжлэх ухааны их сургууль | Гарын авлагыг орчуулж эрүүл мэндийн байгууллагад хүргүүлсэн байна. |
| 9 | Эмзүйн албанд тухайн эмнэлэгт ашиглаж буй эмчилгээний стандарт, удирдамж, хөтөчийн мэдээний санг цаасан болон цахим хэлбэрээр бий болгож, гарын дор ашиглах боломжтой болгох | + | + | + | Эрүүл мэндийн байгууллагууд | Тухайн эрүүл мэндийн байгууллагын эмчилгээ, оношлогоонд хэрэглэж буй эмчилгээний удирдамж хөтөчийн мэдээний сан эмзүйн албанд бий болж, эмнэлзүйн эм зүйч нар өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглаж хэвшсэн байна. |
| 10 | Эмнэлзүйн эмзүйч нь өвчтөнүүдэд үзүүлж буй эмийн аюулгүй байдал, гаж нөлөөний бүртгэлд хяналт тавьж, эмэн эмчилгээний хорооны хурлаар хэлэлцүүлэн арга хэмжээ авч, холбогдох эрх бүхий байгууллагад мэдээлийг ЭМХТ-д тогтмол хүргүүлж байх | + | + | + | Эрүүл мэндийн байгууллагуудын эм зүйн алба | ЭМС-ын холбогдох тушаал, шийдвэр журмыг мөрдөж ажиллах |
| **иглэл 3. Эмнэлгийн болон бусад удирдлагын зүгээс эмнэлзүйн эмзүйчийн сурч боловсрох, хөгжих чиглэлээр дэмжлэг үзүүлэх** | | | | | | |
| 1 | Байгууллагын удирдлагын зүгээс эмнэлзүйн эмзүйч нарыг чадавхжуулахад дэмжлэг үзүүлж жил бүр мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулах | + | + | + | Эрүүл мэндийн байгууллагууд | Тухайн эрүүл мэндийн байгууллагга сургалтад хамрагдсан эмнэлзүйн эмзүйчийн тоо |
| 2 | Эмнэлгийн эмэн эмчилгээг зохицуулах хорооны бүрэлдэхүүнд эмнэлзүйн эмзүйчдийг оролцуулж, эмийн хэрэглээний талаар мэдээлэл сонсох, сонгож буй эмийн талаар зөвлөгөө өгдөг болгох | + | + | + | Эрүүл мэндийн байгууллагууд | Эмийн эмчилгээг зохицуулах хорооны бүрэлдэхүүнд нэмэгдэж орсон эмнэлзүйн эмзүйчийн тоо |
| 3 | Бусад төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай | | + | | Улсын 3 дугаар төв | Зохион байгуулагдсан сургалтд |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | мэргэжлийн төвийн эмнэлзүйн эмзүйч нарт нотолгоонд суурилсан, өвчтөн төвтэй, цаг алдаагүй, эмчилгээний үр дүнтэй, эдийн засгийн үр ашигтай эмийн эмчилгээг хэрхэн удирдан явуулах талаар сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах | | | | эмнэлэг | хэлэлцүүлгийн давтамж, хамрагдсан эмнэлзүйн эмзүйчийн тоо |
| 3.4 | Эмнэлзүйн эмзүйчдийн эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулах | + | + | + | Монголын эмнэлзүйн эмзүйчдийн хөгжил нийгэмлэг, төв эмнэлгүүд | Эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулсан тоо, хамрагдсан эмнэлзүйн эмзүйчийн тоо |
| 3.5 | Иргэд, олон нийтэд эмнэлзүйн эмзүйн тусламж үйлчилгээний зорилго, ач холбогдлын талаар мэдээлэх компанит ажлыг зохион байгуулах | + | + | + | Улсын нэгдүгээр төв эмнэлэг | Зохион байгуулсан арга хэмжээний давтамж тоо, хамрагдсан иргэдийн тоо |
| 3.6 | Эмнэлзүйн эмзүйчид улиралд 1 удаа эмийн эмчилгээнд гарч буй асуудлаа 2-3 тасгийн эмч нартай хамтран шийдвэрлэх "Morning-Forum" хэлэлцүүлгийг эмнэлэгт зохион байгуулж буй туршлагаа төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвд сурталчилж, үзүүлэх сургуулилт явуулах | | + | + | Улсын 2 дугаар төв эмнэлэг | Үзүүлэх сургуулалтийн тоо, хамрагдсан эмнэлгийн мэргэжилтний тоо |
| 3.7 | Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн эмнэлзүйн эмзүйч нарыг эмнэлэгт хэрэглэж буй эмийн сонголт, хэрэглээнд судалгаа хийлгэж 1 бүтээлийг эрдэм шинжилгээний хурал, уулзалтуудад илтгэл тавиулах арга хэмжээ авах | + | + | + | Эрүүл мэндийн байгууллагын удирдлага | Эрдэм шинжилгээний хуралд тавигдсан илтгэлийн тоо |
| 3.8 | Эмнэлзүйн эмзүйн чиглэлийн судалгааг бусад нарийн мэргэжлийн эмч, мэргэжилтэнүүдтэй хамтран хийх нөхцөл боломжоор хангах, эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах | + | + | + | Монголын эмнэлзүйн эмзүйчдийн холбоо, нийгэмлэг, төв эмнэлгүүд, АШУҮИС Эм зүйн сургууль, Эм судлалын тэнхим | Эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулсан тоо, хамрагдсан эмнэлзүйн эмзүйчийн тоо |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 9 | Эмнэлзүйн эмзүйн чиглэлийн багш, судлаачдыг эмнэлгийн эмнэлзүйн болон эмгэг анатомийн сургалтанд тасралтгүй оролцож хөгжих боломжоор хангах, эмнэлгийн сургалтын албатай хамтран сургалтын үйл ажиллагааг тасралтгүй явуулах зөвшөөрөл авах | + | + | + | Монголын эмнэлзүйн эмзүйчдийн холбоо, нийгэмлэг, төв эмнэлгүүд, АШУҮИС Эмзүйн сургууль, Эмзүйн шинжлэх ухааны их сургууль | Эмнэлгийн сургалтын албатай хамтран зохион байгуулсан сургалтын тоо |
| 10 | АШУҮИС-ийн Эмнэлзүйн Эмзүй, менежментийн тэнхимийн багш нар эмнэлзүйн эмзүйчийн асуудал шийдвэрлэхэд болон сургалтанд чиглүүлэх, зөвлөх үүрэгтэй оролцох, дэмжих | + | + | + | АШУҮИС Эмзүйн сургууль | Зөвлөгөө өгсөн эрүүл мэндийн байгууллагын тоо, давтамж |